



ДИЖИТАЛ ЭКСЧЕЙНЖ МОНГОЛИА


Е.АРИЛЖАА ХИЙХ ЗААВАР

Е.АРИЛЖАА ХИЙХ ЗААВАР


1. ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

1.1 НӨХЦӨЛТ АРИЛЖААНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ


➤ АЛХАМ 1. Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



➤ АЛХАМ 2. Арилжаа цэсийг сонгоно.



▶ **АЛХАМ 3.** Хослол дундаас өөрийн арилжаа хийх хослолоо сонгоно.



▶ **АЛХАМ 4.** Авах/Зарах захиалга өгөх хэсгийг ямар захиалга өгөхөөс хамаарч сонгоно.

Нөхцөлт цэсийг сонговол нөхцөлт үнийн захиалга өгнө.

НӨХЦӨЛТ
ЗАХ ЗЭЭЛ

TRD АВАХ

₮ 672.479 MNT

Ханш 1 MNT

Хэмжээ 2 TRD

0%

Нийт 0 MNT

3 TRD Авах

TRD ЗАРАХ

₮ 7,318.783 TRD

Ханш 1 MNT

Хэмжээ 2 TRD

0%

Нийт 0 MNT

3 TRD Зарах

1. **Ханш** хэсэгт авах/зарахыг хүсэж буй ханшийн үнийг оруулна.
2. **Хэмжээ** хэсэгт авах/зарахыг хүсэж буй тоо хэмжээгээ оруулна.
3. **Авах/Зарах** товчийг дарж захиалга өгнө.



- » Ханш болон хэмжээг оруулахад Нийт дүн автомаар бодогдоно.
- » Ханшийн үнийг оруулаад Хэрчим дээрээс нийт дүнгийн хэмжээг сонгосон тохиолдолд хэмжээ нь автоматаар бодогдоно.



Анхааруулга: Trade.mn нь крипто валютын цахим арилжааны бирж тул биржийн арилжааны зарчимаар бүх арилжаа хийгдэнэ. Нөхцөлт буюу дуудлага арилжааны зарчим нь арилжаанд оролцогчдийн хариу үйлдэл дээр тулгуурлан явагдана. Энэ нь идэвхтэй байгаа авах, зарах захиалгуудын ханш хоорондоо таарах үед арилжаа хийгдэнэ гэсэн ойлголт юм. Хэрэв таны оруулсан захиалгын ханш зах зээлийн ханштай таарахгүй бол ханш таарах захиалга орж ирэх хүртэл, эсвэл та өөрөө цуцалтал идэвхтэй хүлээгдсээр байдаг. Хэрэв та койн авах захиалга өгч байгаа бол шимтгэл нь таны захиалга биелсэний дараа тухайн авсан койноос нь бодогдоно. Харин зарах захиалга өгсөн бол таны захиалга биелэх үед төгрөгөөс хасагдаж бодогдоно.

1.2 ЗАХ ЗЭЭЛ АРИЛЖААНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ

➤ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



Нэвтрэх


Та доорх URL-р вэб хөтөчөөс орж байгааг сайтар шалгана уу!

<https://trade.mn>

ИМЭЙЛ

НУУЦ УГ


[Нууц үг мартсан?](#)

I'm not a robot 

[Privacy](#) [Terms](#)

Нэвтрэх


➤ **АЛХАМ 2.** Арилжаа цэсийг сонгоно.



Крипто арилжааг минутын дотор...

Bitcoin, Ethereum, BNB гэх мэт дэлхийн томоохон криптог худалдан авах боломжтой.

▶ **АЛХАМ 3.** Хослол дундаас өөрийн арилжаа хийх хослолоо сонгоно.



▶ **АЛХАМ 4.** Зах зээл захиалга өгөх

Зах зээл захиалга өгвөл зах зээл дээрх хамгийн боломжит дүнгээр захиалга шууд биелэнэ.

НӨХЦӨЛТ **ЗАХ ЗЭЭЛ**

TRD АВАХ 672.479 MNT

Ханш 1

Зах зээл MNT

Дүн 2

MNT

0%

TRD Авах

1. Ханш хэсэгт ханш оруулахгүй зах зээл дээрх хамгийн боломжит дүнгээр биелдэг.
2. Дүн хэсэгт хэтэвчний боломжит үлдэгдэлийн хэмжээнд тааруулан дүн оруулна.

НӨХЦӨЛТ **ЗАХ ЗЭЭЛ**

TRD ЗАРАХ 7,318.783 TRD

Ханш 1

Зах зээл MNT

Хэмжээ 2

TRD

0%

TRD Зарах

1. Ханш хэсэгт ханш оруулахгүй зах зээл дээрх хамгийн боломжит дүнгээр биелдэг.
2. Хэмжээ хэсэгт зарахыг хүсэж буй хэтэвчинд байгаа койны тоо хэмжээнд тааруулан койны хэмжээг оруулна.


Анхааруулга: Trade.mn нь крипто валютын цахим арилжааны бирж тул биржийн арилжааны зарчимаар бүх арилжаа хийгдэнэ. Зах зээлийн зарчим нь захиалгад байгаа хамгий боломжит үнээр арилжаа автоматаар биелэнэ гэсэн ойлголт юм.

Авах тохиолдолд: Зах зээл дээр тогтсон ханшийн хамгийн бага үнээс эхлэн автоматаар биелэнэ.


Зарах тохиолдолд: Зах зээл дээр тогтсон хамгийн өндөр үнээр автоматаар биелэнэ.

2. ЗАХИАЛГА ЦУЦЛАХ

➤ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.




➤ **АЛХАМ 2.** Арилжаа цэсийг сонгоно.




➤ **АЛХАМ 3.** Идэвхтэй захиалгууд хэсэгт таны оруулсан ханш нь таарч биелээгүй захиалга харагдах болно.

» Өөрийн идэвхтэй захиалгын хойно байх **Цуцлах** гэсэн товчин дээр дарна.




▶ **АЛХАМ 4.** Анхааруулгын самбар дээрх **Тийм** гэсэн товчин дээр дарж цуцална.




Анхааруулга: Хэсэгчлэн биелэж байгаа захиалгыг цуцлах үед шимтгэл нь таны биелсэн хэмжээнд бодогдож, цуцалсан койн/төгрөг нь таны хэтэвчинд буцаж ордог. Цуцалсан захиалгын бичилтээ Захиалгын түүх хэсгээс харах боломжтой.

3. АРИЛЖАА БОЛОН ЗАХИАЛГЫН ТҮҮХ ШАЛГАХ



▶ **АЛХАМ 1.** Trade.mn вэбээр хандан өөрийн бүртгэлээр **нэвтэрч** орно.



➤ **АЛХАМ 2.** Арилжаа цэсийг сонгоно.




➤ **АЛХАМ 3.** Захиалгын түүх/Арилжааны түүх гэсэн сонголтыг сонгоно.



➤ **АЛХАМ 4.** Хослол хэсэгт та тухайн харахыг хүссэн койны хослолыг сонгож харах боломжтой.

➤ **АЛХАМ 5.** Огноо хэсэгт та хайлтын хугацаагаа оруулах боломжтой.

➤ **АЛХАМ 6.** Хайх товчин дээр дарж түүхээ хайна.



Анхааруулга: Захиалгын түүх хэсэгт таны Биелсэн захиалга болон Цуцалсан захиалгын түүхүүд харагддаг. Харин Арилжааны түүх хэсэгт зөвхөн таны биелсэн захиалгууд харагдах болно.